




ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2019.07.29-08.02

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 2019 он гарснаас хойш хамгийн ихээр уналаа. Ялангуяа мэдээлэл технологийн компаниудын хувьцаанаас бүрддэг Nasdaq индекс хамгийн их уналтыг үзүүлжээ. Энэхүү уналтын үндсэн хоёр шалтгаан нь Холбооны нөөцийн сангийн бодлогын хүүг бууруулж буй талаарх мэдэгдэл болон БНХАУ-аас АНУ руу орж ирэх импортын бүтээгдэхүүнүүдэд тавих гаалийн татвар юм.

S&P 500 индексийн сагсанд багтаж буй мэдээлэл технологийн компаниудын болон тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан бол үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

Лхагва гарагт хөрөнгө оруулагчдын таамаглаж байснаар Холбооны нөөцийн сан бодлогын хүүний төвшнийг 0.25 нэгжээр бууруулсан байна. Холбооны нөөцийн сангийн Ерөнхийлөгч ноён Жером Пауэл мөнгөний бодлогын хурлын дараагаар хэвлэлийн хурал зарлаж, бодлогын хүү бууруулах болсон шалтгаанаа "шилжилтийн үеийн мөнгөний бодлогын тохируулга" хэмээн тайлбарласан нь зарим хөрөнгө оруулагчдад мөнгөний збодлогыг зөөлрүүлээгүй гэсэн ойлголт төрүүлж хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Дональд Трамп 9 сарын 1-нээс эхлэн БНХАУ-аас импортолдог 300 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнд 10 хувийн гаалийн татвар ногдуулахаа өөрийн "Twitter" хуудаснаа зарласан нь Уолл Стритийг цочроосон ба БНХАУ-тай худалдаа эрхэлдэг компаниудын хувьцааны ханш ихээхэн уналтанд оржээ.

Европ: Европын хувьцааны зах зээл энэ долоо хоногт огцом уналттай хаагдлаа. Энэхүү уналт нь АНУ болон БНХАУ-н худалдааны хоорондын худалдааны маргааны асуудал даамжирч, энэ нь цаашлаад дэлхийн эдийн засгийн өсөлтийг удаашруулж байгаатай холбоотой юм.

Их Британи улс Европын холбооноос ямар нэгэн хэлэлцээргүй гарах магадлал нэмэгдэхийн хэрээр 7-р сард фүнтийн ханш ам.долларын эсрэг ойролцоогоор 4%-аар суларчээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт уналттай байлаа. Гэсэн хэдий ч Баасан гарагт иенийн ханш ам.долларын эсрэг чангарч, 2019 оны хамгийн дээд төвшинд хүрлээ.

Японы төв банк богино хугацааны бодлогын хүүг -0.1% болон урт хугацааны бодлогын хүүг 0.0%-тай ойролцоо хэвээр байлгахаар шийдвэрлэв. Японы төв банкны эрх бүхий албан тушаалтнууд инфляцыг зорилтот төвшинд барьж чадахгүй бол нэмэлт арга хэмжээ авах талаар мэдэгдлээ.

БНХАУ: АНУ болон БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал даамжран, АНУ БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулах талаар мэдэгдэл гарсны дараа БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд огцом уналаа.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп нь хоёр улсын хоорондын уулзалтаас ердөө нэг өдрийн дараа гаалийн татвар ногдуулах талаар мэдэгдэл хийсэн нь БНХАУ-ын эрх баригчдын цочролд оруулжээ.

Шинжээчид ойрын хугацаанд АНУ болон БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудалд шийдэл гарахгүй хэмээн үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,565.38	1.64% ▲
Dow Jones	АНУ	26,485.01	-2.60% ▼
S&P 500	АНУ	2,932.05	-3.10% ▼
Nasdaq	АНУ	8,004.07	-3.92% ▼
S&P/TSX	Канад	16,271.66	-1.57% ▼
FTSE 100	Их Британи	7,407.06	-1.88% ▼
S&P/ASX 200	Австрали	6,687.40	-1.56% ▼
Nikkei 225	Япон	21,087.16	-2.64% ▼
Hang Seng	Хонг Конг	26,918.58	-5.21% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.44
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.14
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.32
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.30
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.13
DBM' 2023	USD	7.250%	104.65
TDBM' 2020	USD	9.375%	103.08

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.228	-0.01 ▼
Libor 3M	2.239	-0.03 ▼
Libor 6M	2.130	-0.07 ▼
Libor 1YR	2.110	-0.09 ▼
US 2YR Bond	1.635	-0.21 ▼
US 3YR Bond	1.589	-0.22 ▼
US 5YR Bond	1.578	-0.26 ▼
US 10YR Bond	1.768	-0.29 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.08.02	Өөрчлөлт
USD	2,666.99	0.06% ▲
CNY	384.47	-0.77% ▼
EUR	2,962.76	-0.19% ▼
RUB	41.27	-2.23% ▼
KRW	2.22	-1.33% ▼
JPY	24.94	1.67% ▲
CAD	2,017.47	-0.26% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,440.83	1.55% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	16.20	-1.19% ▼
Зэс	USD/lb.	257.15	-4.23% ▼
Нүүрс	USD/MT	74.90	1.12% ▲
WTI газрын тос	USD/bbl.	55.66	-0.96% ▼
Brent газрын тос	USD/bbl.	61.89	-2.47% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.12	-2.30% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VI	8.10%
Бодлогын хүү	2019. VI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VI	11.13%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VI	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VI	10.68%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 43 компанийн 377.5 сая төгрөгийн 1,479,564 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“МИК Холдинг” /MIK/ компанийн хувьцаа 27.04%-аар буюу хамгийн ихээр өсөж 14,000.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Өндөрхаан” /ONH/ компанийн хувьцаа 27.50%-аар буурч 2,262.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


8-р сарын 02-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,529.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,565.38 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.64%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	377.5
Зах зээлийн үнэлгээ	2,529,099.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,565.38	1.64% ▲
MSE I индекс	9,425.36	5.61% ▲
MSE II индекс	8,138.89	-0.38% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Говь	377,192	134,383,208
Монгол базальт	494,119	30,410,078
Таван толгой	90,110	25,997,225
АПУ	338,708	23,665,698
Инвескор ББСБ	36,412	20,499,483

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
МИК Холдинг	14,000.00	27.04% ▲
Дархан гурил тэжээл	1,836.00	14.97% ▲
Говь	319.57	12.43% ▲
Эрдэнэ Ресурс Девелопмент корпорэйшн	534.00	11.62% ▲
Ариг гал	3,458.00	8.06% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Өндөрхаан	2,262.00	-27.50% ▼
Мерекс	22.56	-27.23% ▼
Улаанбаатар хивс	17,000.00	-26.09% ▼
Баян-Алдар	1,000.00	-24.36% ▼
Авто импекс	1,890.00	-14.86% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал	93,557,630
Ти Ди Би Капитал	85,954,863
Гаули	77,091,647
БиДиСек	74,954,023
Бумбат-Алтай	70,572,734

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	552.73	588,205
Таван толгой	6,550.00	344,957
МИК Холдинг	14,000.00	289,930
Говь	319.57	249,301
Инвескор ББСБ	1,830.00	131,262

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Жинст Увс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Жинст Увс” ХК нь 2018 оны 4 сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-г нэгтгэх замаар компаниа өөрчлөн зохион байгуулах, өөрчлөн зохион байгуулагдсан компанийн оноосон нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болгон өөрчлөхөөр шийдвэрлэсэн билээ.

Энэхүү өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагааг Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрч (2019 оны 5 сарын 8-ны өдөр зөвшөөрч, 102 тоот тогтоол, 2019 оны 6 сарын 20-ны өдөр 428 тоот шийдвэр), 2019 оны 7 сарын 18-ны өдөр холбогдох өөрчлөлтүүдийг Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгэсэн. Иймд “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг “Жинст Увс” ХК шилжүүлэн авсан, “Жинст Увс” ХК нь оноосон нэрээ өөрчилж “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болсныг тус тус мэдэгдэж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол базальт: Эхний хагас жилд борлуулалтын орлого 75%-аар өсжээ

Дотоодын дулаалгын материалын гол үйлдвэрлэгч “Монгол базальт” /MSE:MBW/ компани 2019 оны эхний хагас жилийн тайлангаа танилцууллаа.

Тайлант хугацаанд 1.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, 123.3 сая төгрөг буюу нэгж хувьцаандаа EPS = 2.2 төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал 479.0 сая төгрөгөөр буюу 74%-аар өсжээ. Өнгөрөгч оны эхний хагас жилд алдагдалтай ажиллаж байсан бол энэ жил ашигтай ажиллаж эхэлжээ.

“Монгол базальт” /MSE:MBW/ компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл “2019 оны эхний хагас жилд техник технологи, судалгаа хөгжүүлэлт, бүтээгдэхүүний төрөл, стандартын шинэчлэлийн ажлуудыг хийж, цаашид “Ил тод байдал”-ын хүрээнд мэдээлэл, тайлагналаа улам бүр сайжруулан ажиллаж байна” гэж мэдэгдлээ.

Тус компанийн хувьцаа оны эхнээс МХБ-ийн ТОП-20 индексийн сагсанд багтаж, зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх болсон бөгөөд хувьцааны ханш нь он гарснаас хойш 118.9 төгрөг буюу 49.3%-аар өсөж 7 сарын 31-ний өдрийн байдлаар 360 төгрөгийн хаалтын ханштай байна.

Онцлон хэлэхэд сүүлийн үед компанийн хувьцаа хоёрдогч зах зээл дээр идэвхтэй арилжигдаж байгаа бөгөөд энэ нь гадны урт хугацааны хөрөнгө оруулагчид идэвхтэй сонирхон орж байгаагаар холбоотой.

Одоогийн байдлаар нийт хувьцааны 70.0%-ийг 5 том хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бол үлдсэн 30.0% нь 2,260 гаруй жижиг хувьцаа эзэмшигчийн мэдэлд байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Шунхлай Групп” “АПУ” компанийн хувьцааны 50.84%-ийг эзэмшлээ

“АПУ” /MSE:APU/ хувьцаат компанийн хувьцаа эзэмшлийн бүтцэд томоохон өөрчлөлт сүүлийн үед ажиглагдах болсон. Тэгвэл компанийн зүгээс энэхүү өөрчлөлтийг батлав.

Энэхүү өөрчлөлтөөр “Wit Alliance Limited” болон “Туул инвернэшнл” компаниуд өөрийн эзэмшлээ “Шунхлай групп”-д шилжүүлсэн байна.

Ингэснээр “Шунхлай групп” нь “АПУ” /MSE:APU/-ийн 50.84%-ийг эзэмшихээр боллоо.

Эх сурвалж: MarketInfo.mn

Дархан нэхий: Бизнесээ охин компаниуддаа шилжүүлснээр борлуулалт болон ашиг эрс буурав

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Дархан нэхий” /MSE:NEH/ компани 2019 оны хагас жилийн тайлангаа зарлалаа.

Тайлант хугацаанд компани 160.8 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 1.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2018 оны мөн үеэс борлуулалт 97%-аар, цэвэр ашиг 90%-аар тус тус буурсан байна.

Ашигт ажиллагаа өндөр хэмжээгээр буурсан шалтгаан нь компани бүтцийн өөрчлөлт хийн өөрийн гол бизнесүүдээ охин компаниуддаа шилжүүлж, зөвхөн менежментийн чиглэлээр ажиллах болсон нь нөлөөлсөн.

Хувьцааны ханшийн тухайд 2019.07.31-ний байдлаар 15,000 төгрөг байгаа нь энэ оны эхнээс 17%-аар буурсан үзүүлэлт юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

Дархан гурил тэжээл: Эхний хагас жилд 107.35 сая төгрөгийн алдагдал хүлээв

МХБ-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй “Дархан гурил тэжээл” /MSE:DAR/ хувьцаат компани 2019 оны 6-р сарын байдлаар 8.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 107.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Компанийн орлого болон алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс буурчээ.

Тус компани өнгөрөгч 4-р сард болсон ХЭХ-ын шийдвэрийн дагуу нэгж хувьцаагаа 1,000 хувааж, мөн нэмж хувьцаа гаргахаар ажиллаж байгаа юм.

Хувьцааны арилжааны тухайд зах зээл дээр идэвхтэй арилжаалагддаггүй хувьцаа бөгөөд хаалтын ханш нь 1,597 төгрөг байна. Харин компанийн борлуулалтын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 54%-аар буурчээ.

Эзэмшлийн бүтцийг харвал 5 хувьцаа эзэмшигчийн мэдэлд

нийт хувьцааны 89.73% нь, 1,250 жижиг хувьцаа эзэмшигчдэд 10.27% нь байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

Шарын гол: Эхний хагас жилд 500 сая төгрөгийн алдагдал хүлээв

Дархан-Сэлэнгийн эрчим хүчний станцуудын гол нүүрс нийлүүлэгч “Шарын гол” /MSE:SHG/ компани 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаа танилуулав.

Тайлант хугацаанд тус компани 27.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ. Орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.7 тэрбум төгрөг буюу 32%-аар өссөн байна.

Харин ашигт ажиллагааны тухайд 507 сая төгрөгийн алдагдал хүлээсэн ба үүнд бүтээгдэхүүний өртөг болон зардлын өсөлт гол нөлөөг үзүүлжээ.

Хувьцааны ханш нь 2019.08.02-ны өдрийн байдлаар 1,551 төгрөг байгаа нь оны эхнээс 13.9%-аар бага үзүүлэлт юм.

Эх сурвалж: MarketInfo.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Жан-Себастьян Жак: Оюутолгой бол дэлхийн хэмжээний төсөл, үнэлгээнд санаа зовохгүй байна

“Rio Tinto” компанийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 12 хувиар өсөж 4.9 тэрбум ам.доллар хүрэхэд төмрийн хүдрийн гэнэтийн хомсдол үүсэн, ханш өссөн нь голлон нөлөөлсөн гэж тайландаа дурджээ.

“Rio Tinto”-ийн орлогын 60 хувийг төмрийн хүдрийн бизнес бүрдүүлдэг байгаа. Гэхдээ компанийн захирал Жан-Себастьян Жакаас тодруулахад тайлант хугацаанд бүрэн хүчин чадлаа дайчлан ажиллаж чадаагүй. Төлөвлөснөөс 8 хувиар бага байсныг хэлсэн байна. Эхний хагаст Австралид цаг уурын нөхцөл таагүй байсантай холбоотой Пилбарагийн уурхайн олборлолтыг бууруулах шаардлагатай болсон. Ингэснээр харьцангуй доогуур чанарын төмрийн хүдэр олборлож, борлуулах шаардлага үүсжээ. Төмрийн хүдрийн ханш энэ он гарснаас хойш 65 хувиар өссөн. Ийнхүү бизнесийн нөхцөл таатай байгаатай холбоотой компани нэг тэрбум ам.долларын тусгай ногдол ашиг тараахаа зарлаад байна.

Хэдийгээр хөрсний нөхцөлийн улмаас Оюу толгойн бүтээн байгуулалтын зардал өсөж ашиглалтад орох хугацаа хойшлох болсон ч “Rio Tinto”-ийн Гүйцэтгэх захирал “Дэлхийд дээгүүр бичигдэх төсөл болох Оюу толгойн үнэлгээнд санаа зовохгүй байгаа” гэжээ. Зардал 1.9 тэрбум хүртэл ам.доллараар өсөж, ашиглалтад орох хугацаа 2.5 жил хүртэл хойшилж болзошгүй байгаа. Энэхүү таагүй мэдээлэл нь компанийн хувьцааны ханшийг огцом унахад хүргэсэн.

Үүнтэй холбоотойгоор Нью-Йоркийн хөрөнгийн бирж “Turquoise Hill Resources”-д анхааруулга өгсөн гэх мэдээлэл байгаа. Учир нь хувьцааны ханш биржээс тавьдаг доод шаардлага болох нэг ам.долларт хүрэлгүй 30-аас дээш хоносон байна. Харин Торонтогийн бирж дэх хувьцааны ханш сүүлийн нэг сард 50 гаруй хувь суларсан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn


Хятадад нүүрсний томоохон ложистик, бааз байгуулж эхэлжээ

Хятадын Шандун мужид коксжих нүүрс нөөцлөх, хуваарилах анхны томоохон бааз байгуулах шав тавьжээ. Энэхүү баазыг коксжих нүүрсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тус улсын 6 компани хөрөнгө оруулж хамтран байгуулж байна. Тэдгээрийн дотор Шанси мужид коксжих нүүрсний олборлолт явуулдаг “Синмин”, төмөрлөгийн үйлдвэрлэлийн “Шэнлун” корпорац багтаж байгаа юм.

Хятадын өмнөд далайн Рижан боомт дахь тус баазыг байгуулахад нийт 1 тэрбум юанийн хөрөнгө оруулж буй тухай “Синмин” корпорацийн захирал Ван Маошэн мэдэгджээ. Уг баазад жилд 10 сая тонн коксжих нүүрс нөөцөлж, эндээс зүүн, зүүн хойд бүс нутаг болон Шандун мужийн гангийн үйлдвэрүүд рүү хуваарилж нийлүүлэх аж. Барилгын ажлыг 2020 онд дуусгаж ашиглалтад оруулах юм байна.

Хятадын нүүрсний ложистикийг хөгжүүлэх төрийн бодлогын зорилтоор нүүрс нөөцлөх, хуваарилах 11 бааз болон бүтэн жилийн турш үйл ажиллагаа явуулах нүүрсний ложистикийн 30 төв байгуулахаар төлөвлөж байгаа тухай тус улсын Хөгжил, шинэтгэлийн хорооноос мэдээлжээ. Рижан нь Хятадын коксжих нүүрсний транзит тээврийн томоохон боомт бөгөөд баруун, зүүн хязгаар нутгийн нүүрсний нийлүүлэлтийг хуваарилдаг далайн чухал гарц юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com



TRQ: II улиралд 736 сая ам.долларын алдагдал хүлээсэн нь “Оюу Толгой”-н гүний уурхайн бүтээн байгуулалтад гарсан хүндрэлтэй холбоотой

II улиралд “Оюу толгой”-н гол хувь эзэмшигч “Turquoise Hill Resources” компани 736.7 сая ам.долларын алдагдал хүлээжээ.

Компанийн зүгээс алдагдал хүлээсэн гол шалтгааныг “Оюу толгой”-н гүний уурхайн бүтээн байгуулалтад гарсан хүндрэлтэй холбон тайлбарлаж байгаа. Гэхдээ 2019 оны эзсийн баяжмалын олборлолтод нөлөөлөхгүй бөгөөд 125,000-155,000 тонн олборлолт хийх төсөөлөлтэй байна. Харин алтны олборлолтын төсөөллийн дээд хэмжээг 220 мянган унцаас 230,000 унци болгож нэмэгдүүлжээ.

Урьдчилсан дүгнэлтээр далд уурхайн ашиглалтад орох хугацаа анхны төлөвлөгөө болох 2021 оны I улирлаас 16-30 сараар хойшлохоор байгаа. 5.3 тэрбум ам.доллараар тооцож байсан төслийн бүтээн байгуулалтын зардал 1.2-1.9 тэрбум хүртэл ам.доллараар өсөж болзошгүйг тайланд тусгажээ. “Одоогоор 2020 оны эцэс хүртэлх бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх хангалттай хөрөнгө байгаа” гэж компани мэдээлсэн. Харин цаашдаа нэмэлт санхүүжилт шаардлагатай. Мөн уурхайг дэмжих Таван толгойн цахилгаан станц болон холбогдох дэд бүтцийн санхүүжилт шаардлагатай байна.

7 сарын 16-нд “Rio Tinto” “Оюу толгой”-н зардал нэмэгдэж уурхайн олборлолт эхлэх хугацаа 2023 он болж хойшилсон тухай мэдэгдсэний дараа “Turquoise Hill Resources”-ийн хувьцааны ханш 40 орчим хувиар огцом унаж байсан. Одоогоор сүүлийн нэг сарын хугацаанд Торонтогийн бирж дэх хувьцааны ханш 2 дахин унаад байна. Компани өнгөрсөн улиралд алдагдал хүлээсэн ч орлого нь 12 хувиар нэмэгджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Зуун хувь ноолууран утсыг 11 өнгөөр үйлдвэрлэн, экспортолж байна

Үндэсний үйлдвэрлэгч “Үлэмж кашимер” ХХК “U” брэндийн шинэ ноолууран утас үйлдвэрлэж байна.

Тодруулбал 100 хувь ноолууран утсаа 11 өнгөөр үйлдвэрлэн гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж эхэлснээ танилцууллаа.

“Үлэмж кашимер” компанийн захирал М.Сосордулам хэлэхдээ, “Дэлхийд “Цагаан алт” хэмээн нэрлэгдэх болсон жил бүр нөхөн сэргээгддэг түүхий эд болох ноолуурыг нэмүүн өртөг шингээж олон улсын зах зээлд гаргаж байна. Бид ноолуурын анхан шатны боловсруулалтын үйлдвэр байгууллаа. Мөн гэрээлэгч компаниудтай хамтран 100 хувь ноолууран утсыг худалдаанд гаргаад байна” гэв.

Эх сурвалж: Montsame.mn

БУСАД МЭДЭЭ

Эдийн засгийг тогтворжуулах бодлогыг дэмжиж, 100 сая ам.долларын санхүүжилт батлав

Дэлхийн банкаас Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулж, цаашид илүү тогтвортой бөгөөд хүртээмжтэй хөгжилд хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 сая ам.долларын санхүүжилт батлав. Уг асуудлыг Дэлхийн банкны Гүйцэтгэх захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дэмжсэн байна.

Дэлхийн банкны Эдийн Засгийн Удирдлагыг Дэмжих цуврал хөтөлбөрийн эхний шатыг 2017 онд батлан хэрэгжүүлсэн. Хоёр дахь санхүүжилтийн 100 сая ам.доллараар өмнөх хөтөлбөрийг үргэлжлүүлэх бөгөөд өрийн тогтвортой байдлыг сэргээх, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн Монгол Улсын бодлогын шинэчлэлийг дэмжиж байгаа юм.

Монгол Улсын эдийн засаг 2016 оны макро эдийн засгийн хүндрэлээс амжилттай гарч чадсан ч суурь эмзэг асуудлууд байсаар байна. Эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2 хувь байсан бол 2018 онд 6.9 хувь болж өссөн. Төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ий 16.4 хувьтай тэнцэж байсан бол 2018 онд 2.7 хувьтай тэнцэх ашигтай гарсан. Энэ нь ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээг дээрх хугацаанд бараг 13 нэгж хувиар буурахад нөлөөлсөн аж. 2014-2016 оны эдийн засгийн идэвхжил саарч байсан үед ядуурал нэмэгдсэн ч эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор ядуурал бага зэрэг буурсан нь хөдөлмөрийн зах зээлд сорилтууд байсаар байгааг болон нийгмийн халамжийн бодлогуудыг илүү үр дүнтэй болгож сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна хэмээн тус зөвлөл үзжээ.

Монгол Улс, БНХАУ, БНСУ-ыг хариуцсан Дэлхийн банкны захирал Мартин Рэйзэр “Энэхүү хөтөлбөр Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, улсын төсөв, санхүүг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулахад чухал үүрэгтэй. Засгийн газраас дээрх асуудлуудыг шийдэхээр ажиллаж байгаа нь эдийн засагт бүтцийн шинжтэй өөрчлөлт хийх бодлого баримталж байгаагийн тод илрэл юм. Дэлхийн банк цаашид Засгийн газар болон олон улсын хөгжлийн түншүүдтэй хамтран Монгол Улсын Эдийн Засгийг сэргээх хөтөлбөрийг дэмжин ажиллах болно” хэмээн онцлов.

Тус хөтөлбөрт татварын тогтолцоо болон төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулах, одоо хэрэгжиж буй улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслийн зардлыг бууруулах, төсвөөс санхүүждэг тусгай сангийн удирдлагыг сайжруулах зэрэг эдийн засгийг тогтворжуулах ажил багтаж буй юм. Түүнчлэн Хөгжлийн банк, Төв банкны сүүлийн жилүүдийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээг олон нийтэд ил болгох, орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хэлбэр, бүтцийг сайжруулах замаар худалдан авах чадварт нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх аж.

Хөтөлбөрийн өөр нэг чухал чиглэл бол уул уурхайн салбараас бусад салбарт ажлын байр бий болгох, нийгмийн хамгааллын бодлогыг зорилтот бүлэгт оновчтой чиглүүлэх замаар ядуу, эмзэг бүлгийн нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх явдал юм. Мөн эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд тусгай зөвшөөрлийн шаардлагыг хялбаршуулах, хөрөнгө оруулагчдын хамгаалалтыг бэхжүүлэх, худалдааг хөнгөвчлөх зэргээр бизнес, худалдааны орчныг сайжруулах боломжийг эрэлхийлж буй аж.

Харин уг хөтөлбөрийн хүрээнд хийхээр төлөвлөж буй гурав дахь шатны санхүүжилт нь ОУВС-ийн хөтөлбөртэй нягт уялдаатайгаар арилжааны банкуудын өөрийн хөрөнгийг нэмэхэд чиглэх аж.

Эх сурвалж: Montsame.mn

Хөрөнгийн биржид 76 компани тайлангаа ирүүлжээ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-иуд нь хуулийн дагуу хагас жилийн санхүүгийн тайлангаа 7-р сарын 20-ны дотор ирүүлэх үүрэгтэй.

Дээрх хугацаанд нийт бүртгэлтэй 199 ХК-иас 76 нь санхүүгийн тайлангаа ирүүлээд байна. Хуульд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй буюу хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлээгүй ХК-ууд 8-р сарын 1-ний өдрийн дотор зөрчлөө арилгаагүй тохиолдолд Монголын хөрөнгийн бирж болон СЗХ-ны холбогдох журмууд болон “Бүртгэлийн гэрээ”-нд заасны дагуу хариуцлага ногдуулах юм.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-иуд Үнэт цаасны зах зээлийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу олон нийтэд нээлттэй, ил тод байх компанийн засаглалын сайн жишгийг хангаж, тайлангаа хүргүүлсэн байх ёстой аж.

Эх сурвалж: Montsame.mn



Хэрэглээний үнэ нийслэлд 0.8 хувиар өсжээ

Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ нийслэлд 0.8 хувиар өссөн талаар өнөөдөр Монголбанкнаас мэдээлэв.

Инфляц өнгөрсөн зургадугаар сарын байдлаар улсын хэмжээнд 8.1 хувь, Улаанбаатар хотод 9.6 хувь байв. Харин энэ сард инфляци өсөхөд хувцас болон амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дээшилсэн нь нөлөөлжээ. Өмнөх сард нийлүүлэлтийн хомсдлоос шалтгаалж махны үнэ өссөн нь энэ сард буураагүй нь мөн нөлөөлсөн байна. Хоёр улсын худалдааны нийт эргэлт 70 гаруй сая ам.доллар байгаагаас экспорт 43.4 сая, импорт 33.3 сая ам.долларт хүрээд байна.

Шатахууны хилийн үнэ газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнийн савлагааг даган өөрчлөгдөж байгаагаас дотоодын шатахууны үнэ 4, 5 дугаар саруудад өссөн. Харин тавдугаар сарын дундаас газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнэ буурснаар өнгөрсөн сард дотоодын шатахууны үнэ 30-40 төгрөгөөр буурав.

Манай улсын аялал жуулчлалын идэвхтэй улирал зургадугаар сараас эхэлдэг. Үүнийг даган дотоодын аялал жуулчлалын үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байдаг. Тайлант сард дотоодын аялал жуулчлалын үйлчилгээний үнэ өмнөх сараас 56.8 хувиар огцом өссөн гэдгийг Монголбанкны мэдээлэлд дурджээ.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.